

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон нийт тэтгэвэр авагчид баталгаат тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүртэл хугацаанд тооцон олгох бөгөөд баталгаат тэтгэврийн хэмжээ нь баталгаат тэтгэврийн суурь дүн (Бс)-тэй тэнцүү байна.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өдрөөс эхлэн баталгаат тэтгэвэр (Бт), баталгаат тэтгэврийн суурь дүн (Бс)-гийн зөрүүг олгоно.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш тэтгэвэр тогтоолгосон бөгөөд өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр (Бт)-ийг олгоно.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ